



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
E-мэйл: dundgov@audit.gov.mn

2020-07-31 № 119.

танай -ны № -т

Г  
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэлгэрхангай сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дэлгэрхангай сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Монгол ардын нам” -ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг,


“Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дэлгэрхангай сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /.....<sup>5</sup> хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дэлгэрхангай сумын сонгуулийн хороонд

Хавсралт .<sup>5</sup> хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА



ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМААС ДЭВШҮҮЛЭХ МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР



ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН

1. Иргэний хөгжлийн бодлого
2. Сайн засаглалын бодлого
3. Хөдөө аж ахуйн бодлого
4. Эдийн засгийн бодлого
5. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын бодлого

НЭГ ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- ✓ Эрүүл иргэн
- ✓ Боловсролтой иргэн
- ✓ Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн
- ✓ Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх
- ✓ Ажилтай, орлоготой иргэн
- ✓ Залуучуудын хөгжлийг дэмжинэ
- ✓ Ахмадын хөгжлийг дэмжинэ..
- ✓ Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил

ТАВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

- ✓ Эдийн засгийн үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- ✓ Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.

**1.1 Эрүүл иргэн.**

1.1.1 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.2 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлж эмчлэн, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.3 Авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандарт түвшинд хүргэж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.1.4 Малчин бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.5 Спортын бага наадмыг 2 жил тутам зохион байгуулна.

1.1.6 Архигүй Дэлгэрхангай хөтөлбөрийг эрчимжүүлж ажиллах.

**1.2. Боловсролтой иргэн**

1.2.1 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоод сургалт, үйл ажиллагаанд хамруулж “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.2 Жил бүр сургууль цэцэрлэгийн шилдэг багш ажилчдыг шалгаруулж боловсролын салбарын ажилчдын нийгмийн асуудал ажиллах орчныг нөхцөлийг сайжруулна.

**1.3 Үндэсний өв, соёл урлагийг дэмжигч иргэн**

1.3.1 Дэлгэрхангай сумын 100 жилийн ойн нэгдсэн тогтолт Улаанбаатар Дундговь аймагт зохион байгуулна



1.3.2 Ногоон дээвэрт анхны сургуулиа орон нутаг судлах тэнхим болгоно.

#### **1.4 Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн**

1.4.1 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган алхах, дугуй унах зориулалтын зам талбайтай болгоно.

1.4.2 Төрийн албан хаагч нарын дунд урлаг, спортын их наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

1.4.3. Нийт хүн амын дунд соён гэгээрүүлэх үйл ажиллагааг 1 жил тутам

#### **1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог нэмэгдүүлэх**

1.5.1 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

1.5.2 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд хэрэгцээт үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж нийтийн эзэмшлийн барилга талбайд зориулалтын зам, шатыг суурилуулна.

#### **1.6 Ажилтай, орлоготой иргэн**

1.6.1 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.6.2 Их дээд болон мэргэжлийн сургууль төгсөж залуучуудыг орон нутагтаа ажиллах боломж нөхцөлөөр хангана.

1.6.3 Зорилтод бүлгийн иргэдийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран ажлын байраар хангана.

#### **1.7 Залуучуудын хөгжлийг дэмжинэ**

1.7.1 Гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин төвүүдийг бий болгоно.

1.7.2 Орчин үеийн стандартад нийцсэн кино театрын барилгын ажлыг эхлүүлнэ.

1.7.3 Дэлгэрхангай сумын Залуучуудын хөгжлийн төвийг бий болгож үйл ажиллагааг сайжруулна.

1.7.4 Оюутан залусыг гадаадад сургах боловсон хүчний бодлого боловсруулна.

#### **1.8 Ахмадын хөгжлийг дэмжинэ**

1.8.1 Хөдөлмөрийн чадвартай ахмадуудын орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.8.2 Ахмадуудын урлаг, спортын наадмыг 2 жил тутамд зохион байгуулна.

#### **1.9 Нийгмийн хамгааллын бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ**

1.9.1 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг чанаржуулна.

1.9.2 Зорилтод бүлгийн өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.

#### **1.10. Хүүхэд, гэр бүл эмэгтэйчүүдийн хөгжил**

1.10.1 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж хүүхдэд аюулгүй бүрдүүлнэ.

1.10.2 Эмэгтэйчүүдийн товлолт дархлаажуулалтыг нэвтрүүлж умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах “Энх Бүсгүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## **2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба**



2.1.1 Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.

2.1.2 Авилгаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

2.1.3 Шилдэг төрийн албан хаагчийг шалгаруулах

## **2.2 Хүнд сурталгүй -цахим Дэлгэрхангай**

2.2.1 Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.2 Иргэд, олон нийттэй харилцах мэдээллийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлж төр иргэний эргэх холбоог сайжруулна.

## **2.3 Шилэн төндөрийг зохион байгуулна.**

2.3.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Төндер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

2.3.2 Аймаг сумын бүх төрийн байгууллагуудын “шилэн данс”-ыг хөтлүүлж, мэдээллэнэ.

## **2.4 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.**

2.4.1 Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

2.4.2 Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллана.

2.4.3 Хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтлах, ашигт малтмалын хайгуул, ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг жилд төлөвлөгөөний дагуу хийлгэх.

## **2.5 Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.**

2.5.1 Үндны усны эх үүсвэрийг шинэчлэн тогтооно.

2.5.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нийт газар нутгийн 30 хувьд хургэнэ.

2.5.3 Сумын хог хаягдлын менежментийг сайжруулна.

## **3.1 Малчдын амьжиргааг сайжруулна.**

3.1.1 Монгол малын махны олон улсад сурталчилна таниулж “Дундговийн Max”, “Дундговийн Айраг” “Дэлгэрхангай брэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.1.2 Малчдын орлогыг тогтвортой байлгахад анхааран “ Ноолуур” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.1.3 Хөдөөгийн интернэт төсөл хэрэгжүүлнэ.

3.1.4 Дэлгэрхангайн Брэнд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

## **3.2 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.**

3.2.1 “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

## **3.3 Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.**

3.3.1Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинжуулах ажлыг жил бүр зохион байгуулна.



3.3.2 Мал эмнэлэг үржлийн тасгийн үйл ажиллагааг дэмжиж машин хэрэгслээр хангана.

#### **3.4 Бэлчээрийн менежментийг сайжруулна.**

3.4.1 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж бэлчээрт гүн өрмийн худаг жилд 4-өөс доошгүй, энгийн уурхайн худаг 10-аас доошгүйг сэргээн засварлах буюу шинээр гаргана.

#### **3.5 Хүнсний болон газар тариаланг дэмжинэ**

3.5.1 Өвөл зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний нарийн ногооны сумын хэрэгцээг хангана.

3.5.2 Суманд усжуулалтыг нэмэгдүүлж чацаргана, төмс, хүнсний ногоо тариалах хувь хүн ,аж ахуйн нэгжийг дэмжинэ.

3.5.3 Сумандаа “Нэг гудамж” төсөлт хэрэгжүүлэх.

3.5.4 Органик-100% хөтөлбөрийг орон нутагт хөгжүүлнэ.

#### **4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ**

4.1.1 Орон нутгийн онцлогтой брэнд хүнсийг зах зээлд гарах менежментийг боловсруулж нутгийн иргэдийн өргөн оролцоотой хоршоодыг баг болгонд байгуулж дэмжинэ.

#### **4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.**

4.2.1 Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагийн наадам г.м/-г сурталчлах.

#### **4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл**

4.3.1 “Дэлгэрхангай түншлэл” арга хэмжээг жил бүр зохион байгуулна

#### **5.1 Эдийн засгийн үр өгөөжөө өгөх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.**

5.1.1. Нөхөрлөл хоршоог дэмжих ажлын байр нэмэгдүүлнэ.

#### **5.2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийнэ.**

5.2.1 Гэр хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

#### **5.3 Хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгана**

5.3.1 Сумын хөгжил “-ийн хүрээнд жишиг сум болгоно.

5.3.2 Сумын халуун усны газрыг шинэчилж, нийтийн ахуйн үйлчилгээний байр барьж, дэд бүтцийг нь сайжруулна.

#### **5.4 Дэд бүтэц**

5.4.1 Цэвэр бохирын шугаманд холбож цэвэрлэх байгууламжийг барина

5.4.2 Бохир соруулах машинтай болох

5.4.2 Хулд- Дэлгэрхангай хатуу хучилттай авто замд холбоно.

5.4.3 24 айлын орон сууцны барилга барина.

5.4.4 Сумын төвд 2км авто зам барина.

5.4.5. Соёлын төвийн их засвар ажлыг хийж гүйцэтгэнэ

5.4.6. Засаг даргын тамгын газрын шинэ барилгыг бариулна

5.4.7 Аялал жуулчлалын бус нутаг болох

5.4.8 Хүүхдийн цэцэрлэгийн тоглоомын шинэ заал барих

5.4.9 Нийтийн аж ахуйн үйлчилгээний байртай болох

5.4.10 Сургуулийн ажилчдын байрыг бүрэн засварлаж цэвэр бохирын шугамтай холбоно

5.4.11 Галын аюулаас урьдчилан сэргийлэх гал унтраах авто машин тоног төхөөрөмжөөр хангана

- 5.4.12 Сумын төвийн айл өрхийн хашааг жишиг болгоно.
- 5.4.13 Гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
- 5.4.14 Сургуулийн дотуур байрны их засвар хийж гүйцэтгэнэ
- 5.4.15 Эрүүл мэндийн төвийг авто машинтай болгох



A handwritten signature in black ink, appearing to read "Далан-Уул".